

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн Засаг дарга 24 сумд, 47 агентлаг, байгууллагын дарга нартай 2020 онд хамтран ажиллах болон үр дүнгийн гэрээг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулав. Энэ үеэр аймгийн 2019 оны "Хүүхэд хамгаалал өрхийн хөгжлийг дэмжих" нэрлэсэн жилийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулж, нэрлэсэн жилийн ажлыг дүгнэн үр бүтээлтэй ажилласан албан байгууллагыг тодруулаа. 2020 оныг "Зүтгэл-Итгэл-Санаачилга"-ыг дэмжих жил болгон зарлаж хөтөлбөр, төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулж, нэрлэсэн нээлтийг энэ үеэр хийв.

Аймгийн Засаг дарга 2020 оны 1 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Индоор хотод Засаг дарга нарт зориулсан Хөгжлийн менежмент богино хугацааны сургалтад хамрагдаж, Индоор, Дели, Агра, Бопал хотуудаар явж туршлага судаллаа.

2020 оны 01 дүгээр сарын 29-31-ний хооронд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Идэр бүсийн сумд болох Төмөрбулаг, Галт, Жаргалант, Шинэ-идэр сумдад өвөлжилтийн нөхцөл байдал, хаваржилтын бэлтгэлтэй танилцах, малчид, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, нөхцөл байдалтай газар дээр нь үзэж танилцах зорилгоор ажиллаж Төмөрбулаг сумын 4-р баг Мод толгой, Галт сумын Салбарт, Харцат, Жаргалант сум 4-р баг Элстийн ам, Шинэ-Идэр сумын 4-р баг Зөөлөн гэсэн газруудад малчны хотонд очиж өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцан холбогдох шийдвэрүүдийг гаргаж, сумдын удирдлагуудад чиглэл өгөв. Дөрвөн сумын 20 гаруй төрийн байгууллагын үйл ажиллагаатай танилцаж нийт 612 төрийн албан хаагчидтай уулзалт хийж тэдний санал бодлыг сонсон тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэн ажиллалаа. Мөн 02 сарын 04-07-ны хооронд Тосонцэнгэл, Тариалан, Их-Уул, Рашаант суманд ажиллаж байна.

Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаар Засгийн газрын референт Б.Нарангуа, Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн ажилтан К.Алтынбек, Австралийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан төгсөгч Ц.Уянга нар 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газар, банк, санхүүгийн байгууллага, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Боловсрол, соёл, урлагийн газруудад ирж төрийн албан хаагч, багш, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өглөө.

Төрийн албан хаагчийн сургалт дэд хөтөлбөрийн хүрээнд "Royal Академи" сургалтын төвтэй хамтран 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 7 төрийн байгууллагын 85 албан хаагчдад "XXI зуунд эзэмших хувь хүний чадамжууд" сэдвээр нэг өдрийн сургалт арга хэмжээг зохион байгуулав.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 01-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 6.1 тэрбум төгрөгний 1264 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 12-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 11.986,2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 13.777,1 сая төгрөг буюу 114.9 хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүсэн байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 100.755,0 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 55.946,5 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 31.376,3 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 964,6 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 8.407,7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 100.755,0 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 97.067,6 мянган төгрөг буюу 95.3 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 5.214,9 сая төгрөг өмнөх сараас 12.8 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс сум хөгжүүлэх сангийн авлага 4.964,6 сая төгрөг байна. Төсөвт байгууллагын авлага 250.2 мянган төгрөг байна.

Нийт өглөг 843,7 сая төгрөг өмнөх сараас 945,9 сая төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын хэлтэсийн сарын шуурхай мэдээ:

2020 оны 01 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1993.8 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 370.3 сая төгрөгийн шимтгэлийн орлого 97.5 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
Тэтгэвэр	1705.5	1569.5	92
Тэтгэмж	145.8	174.5	119.7
Үомшө	92.7	140.3	151.3
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	24.2	35.1	145
дүн	1968.2	1919.4	97.5

Тэтгэврийн даатгалын сангаас 18789 тэтгэвэр авагчид 6233.8 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 258 даатгуулагчдад 154.3 сая төрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 28 даатгуулагчдад 59.0 сая төгрөгийн төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 251.4 сая төгрөг байна.

2020 оны төлөвлөгөөний дагуу нийт 1 суманд 2 төрлийн нийцлийн аудит гүйцэтгэн, “Иргэдийн оролцоотой хяналт” нэрлэсэн жилийн ажлын хүрээнд сум бүрд иргэдийн мэдлэг, мэдээлэлийг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, нийт 2000 иргэнийг хамрууллаа. Дотоод аудитын явцад 151 танилцуулга, тайлан бичиж, төлүүлэх 34 акт тогтоон, зөрчил арилгуулах 52 албан шаардлага тавьж ажиллав. Байгууллагын хэмжээнд 2020 оны 01 дугаарын сарын 31-ны байдлаар 346 албан бичиг хүлээн авч, 63 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 319 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын явцад байгууллагуудын дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллаж, чиглүүлэх ажлыг зохион байгуулснаар аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 2.1.6 дахь “Улсын салбарын дотоод аудитыг улсын жишигт хүргэж, дотоод хяналтын тогтолцоог бүх шатанд төлөвшүүлэх” гэсэн дэд хөтөлбөрийн 1.29.282-д “Бүх шатны төсөв захирагчийн үйл ажиллагааны дотоод хяналт, эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлнэ” гэснийг хэрэгжүүлэхээр шат дараатай гүйцэтгэж буй ажлын нэг хэсэг бөгөөд уг үзүүлэлт өссөн үзүүлэлтээр 60%-тай биелэгдсэн хэмээн үнэлэв.

Оны эхнээс нийт 20 өргөдөл гомдол хүлээн авч 3 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлэн, 16 өргөдөлд хяналт шалгалтыг хийж хариу өгсөн ба хугацаа болоогүй 1 өргөдөл байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсээс Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, бүх төрийн байгууллагууд үйл ажиллагааны хүрээнд Үндсэн хуулийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан, аймгийн Ардын Их Хурлын 9 депутатад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

“Миний Үндсэн хууль-Миний эрх чөлөө” арга хэмжээг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран зохион байгуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг өсвөр үеийн хүүхдүүдэд таниулах, аймгаас сонгогдсон Ардын Их Хурлын депутатуудын үйл хэрэг, захиа сургамжийг залуу хойч үедээ хүргэх, залгамж холбоог бий болгосон үйл ажиллагаа юм.

Нутгийн захиргааны байгууллага болох аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, харъяа агентлаг байгууллагуудын “Нийтийн албан тушаалтнуудын 2019 оны хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийн үйл ажиллагаа

явагдаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд нийт 348 нийтийн албан тушаалтан 2020 оны 02 дугаар сарын 15-ний дотор мэдүүлгээ гаргахаас 02 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 315 хүн мэдүүлгээ гаргасан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Нарантуяа болон Боловсрол, соёл, урлагийн газрын дарга, мэргэжилтнүүдийн баг Дэлгэр мөрөн, Эрдмийн далай, Аваргууд, Авьяас, Ирээдүй 21-р зуун, Сод-Эрдэм сургууль, 1-12-р цэцэрлэгүүдийн багш, удирдлагуудтай уулзаж боловсролын салбарын бодлого үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичгүүдийг танилцуулан мэдээлэл хийж, сургуулийн орчин нөхцөлтэй танилцан зарим тодорхой асуудлуудыг шийдвэрлэн ажилласан.

-Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн захирлал, хүүхдийн цэцэрлэгийн эрхчлэгч нарын албан тушаалын цалинг шинэчлэн тогтоолоо.

-Улсын тэргүүний Дэлгэрмөрөн, Эрдмийн далай, Аваргууд сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад “Малч ухаан” сургалтыг зохион байгуулахаар төсөл төлөвлөгөөг боловсруулан Дэлхийн Зөн ОНХ-т хүргүүллээ.

-ЕБС, СӨБ-ын нярав, эмч, тогооч нарт Хүүхэд хамгааллын бодлого, Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга, Эрүүл ахуй орчны стандарт, хоол үйлдвэрлэлийн чанар хүртээмж, үдийн цай хөтөлбөр, худалдан авах ажиллагаа зэрэг агуулгаар сургалтыг 2020.01.10-нд хийлээ.

-Англи хэлний багш нарын нэгдсэн сургалтыг 2020.01.03-04-нд АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран зохион байгууллаа. Сургалтад 31 сургуулийн 86 багш хамрагдав.

-Баянзүрх сумын Хонин уулын хилийн застав, Мөрөн сумын Зөв эхлэл, Энхжин, Энх-Үйлс зэрэг хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдүүдийн судалгаа, хөгжлийн бэрхшээлтэйг тогтоосон шийдвэр зэргийг БСШУСЯ-ны сургуулийн өмнөх боловсролын хэлтэст хүргүүлж ажилласан.

-Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал, цэвэрлэгээ хийх чиглэлийг цэцэрлэгийн эрхчлэгч нарт хүргүүлж ажилласан.

-Хөл хорио тогтоож сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор судлагдахуун бүрээр цахим хичээл бэлтгэн БСУГ-ын вэб сайтад байршуулан ажиллаж байна.

Соёл, урлаг, спортын чиглэлээр

-Орон нутгийг судлах музей, Хилийн цэргийн 0257 дугаар ангийн Соёлын төвтэй хамтран соёл, олон нийтийн ажлын нээлтэд хамтран оролцож хил хамгаалалтын талаар мэдээлэл сонсож, соёлын өв, музейн талаар мэдээлэл хийж харилцан мэдээлэл солилцож, хилийн цэргийн холбогдолтой үзмэрээр үзэсгэлэн гаргаж, анги бүрэлдэхүүнд үнэ төлбөргүй үзүүлж хамтран ажиллалаа.

-Монгол Улсын Үндсэн хуулийн 28 жилийн ойд зориулан музейн үзмэрээр танилцуулга булан гаргаж иргэд, төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Нийтийн номын сан Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан уншигчдад үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг танин мэдүүлэх зорилгоор уншлагын 3-н танхимд “Таны эрх зүйн

мэдлэгт”, “Шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт”, “Миний үндсэн хууль-Миний эрх чөлөө” номын үзэсгэлэнгүүдийг гаргалаа.

- Нүүдэл зөөврийн номын санг Аймгийн Нийтийн номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, танилцуулах, номтой нөхөрлөх, ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх зорилгоор “Шинэ мөрөн худалдааны төв”-д ажиллуулж 14 шинэ уншигчид карт нээж, шинэ номын үзэсгэлэнг 50 номоор гаргаж, 60 гаруй уншигчид хүргэлээ.

-2020 оны 1 дүгээр сарын 7-14-ний өдрүүдэд Бадминтоны сургалтыг БТСГазарт Япон улсын иргэн Жайкагийн сургагч багш Айка Нагай, БТСГ-ын Бадминтоны дасгалжуулагч Б.Чинбат нар зохион байгуулж гарын авлага зөвлөмж, спорын хэрэглэл материал тарааж өглөө. Сургалт Мөрөн суманд 5 хоног, Хатгалд 1 өдөр зохион байгуулагдаж 74 хүүхэд, багш, ард иргэд 80 гаруй нийт 150 хүн хамрагдан оролцлоо.

-2020.01.10-12-ны өдрүүдэд хүндийн өргөлтийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж 18 байгууллагын 200 орчим тамирчид оролцсоноос Э.Ууганцэцэг огцом өргөлтийн 53 кг, түлхэлттэй өргөлтийн 60 кг, Э.Батчимэг СМ огцом өргөлт 62 кг, түлхэлттэй өргөлтийн 73 кг-ийн төрөлд, Эрэгтэй Ч.Нямбат огцом өргөлтөөр 61кг, түлхэлттэй өргөлтөөр 88 кг, С.Цэнгүүн огцом өргөлтөөр 75 кг, түлхэлттэй өргөлтөөр 91 кг-д 2,3-р байр эзэлж нийлбэр дүнгээр 3 дугаар байранд шалгарлаа.

Паурлифтингийн Улсын аварга шалгаруулах тэмцээн 1 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж тамирчин Ц.Отгондалай 93 кг-ын жинд 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд орон тооны болон орон тооны бус арга зүйчдийн “Сургалтын арга зүйг сайжруулах нь” сургалт 1 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж 23 сум, 15 цэцэрлэгийн 87 хүн хамрагдлаа. Мөн сумдын арга зүйч нарын 2019 оны ажлыг дүгнэж эхний 3 байранд шалгарсан арга зүйчид, мөн хөдөө орон нутаг болон аймгийн төвийн түвшин тогтоох сорил хариуцсан ажилтнуудын ажлыг дүгнэж эхний 3 байрт шалгарсан цэцэрлэгүүдийг шагнаж урамшууллаа.

1 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд “Мөсөн сур”-ын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд зохион байгуулагдаж 13 сумын 58 тамирчин оролцлоо.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 1 дүгээр сараас хүсэлт гаргасан хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгох шийдвэр гарсан бөгөөд 2020 оны 1 сарын 30-ны байдлаар аймгийн хэмжээнд 47820 хүүхэд уг тэтгэмжид хамрагдаж байна.

Нийгмийн халамжийн сангаас батлагдсан төсвийн хүрээнд 16 төрлийн халамжийн үйлчилгээнд 1,3 тэрбум төгрөгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу давхардсан тоогоор 13800 орчим иргэдэд олгон ажилласан.

2020 оны 1-р сард шинээр байнгын ажлын байр-41, улирлын шинжтэй -17, түр-28, нийт 86 ажлын байр бий болсон байна.

Идэвхтэй ажил хайгчаар 676 иргэн бүртгүүлж, 29 иргэн байнгын болон түр ажлын байранд зуучлуулах үйлчилгээг авсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд жижиг зээлийн олгох арга хэмжээ хэрэгжиж байна. Зээл хүссэн 91 иргэнд зээлийн өмнөх сургалтыг зохион байгуулж ажиллав.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр

2019 оны “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн тайлант өдөрлөгийг зохион байгуулав. “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих” нэрлэсэн жилийн хэрэгжилтийг тусгай шалгуурын дагуу үнэлж шилдэг сум 5, шилдэг

байгууллага 5, шилдэг хамтарсан баг 3, байгууллагын дэргэдэх шилдэг эцэг эхийн зөвлөл 3, хүүхдэд ээлтэй байгууллага 3-ийг тус тус шалгаруулав.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх ажлын зохион байгуулалтыг ханган ажиллав. Энэ ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр байгууллагын даргын 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/02 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, 2020 оны 1 сарын 6-ны өдрийн 03 тоот албан бичгээр 24 сум болон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст чиглэл хүргэсэн. Тухай үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.

-“Хүүхэд хүмүүжлийн Эерэг арга” сургалтыг зохион байгуулав. Аймгийн ерөнхий боловсролын 35 сургууль тус бүрээс 3 багш 3 багшийг хамруулан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг 3 үе шаттай зохион байгуулахаар аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗМОУБ-ын “Хөвсгөл” ОНХ, үндэсний сургагч багш нартай хамтран төлөвлөж, тус сургалтын 3-р шатны сургалтыг 2020 оны 1 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан.

-Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн даргаар ахлуулсан “Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах салбар комисс”-ын бүрэлдэхүүнд газрын Гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээ хариуцсан мэргэжилтнийг оруулж, өөрийн байран дээр хурлыг зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулж, сард 2 удаа хуралдаж хэвшсэн. 2020 оны 1 дүгээр сарын 8-нд хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй 39 хүүхдийг хурлаар оруулан хэлэлцэж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, сэргээн засалт, хүүхдийн биеийн болон оюуны хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулж, эцэг эх, асран хамгаалагч нарт гэрийн нөхцөлд хэрхэн зөв дадалд сургах талаар заавар зөвлөмж өгч, үйлчилгээнд хамрагдсан хүүхэд бүрт загвар маягтын дагуу үнэлгээ хийн ажиллалаа.

- Хүүхдийн тусламжийн 108 утсанд бүртгэгдсэн дуудлагын хариу үйлчилгээний мэдээллийг ирүүлэх загвар хүснэгтийг боловсруулж, газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 15 тоот албан бичгээр 24 сум, хамтарсан багт чиглэл болгон хүргэсэн. 2020 оны 1 дүгээр сарын байдлаар 13 дуудлага мэдээлэл ирснийг Мөрөн суманд 7, бусад суманд 6 шилжүүлэв

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих ТББ-с зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай ойлголт сургалтад гэр бүл, хүүхдийн хамгааллын үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч М.Даваадулам, гэр бүл, хүүхдийн эрхийн хэрэгжилт, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Г.Мөнхбилиг нар хамрагдав.

-2020 оны 1 дүгээр сарын байдлаар “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д нийт 32 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн. 19 үйлчлүүлэгч аюулгүй байдлын хамгаалалтанд байрласан.

Үүнээс 11 хүүхэд, 21 насанд хүрэгч байна. Нийт үйлчлүүлэгчдийн 21 нь сэтгэл зүйн зөвлөгөө, 23 хүнийг цагдаагийн газар болон шүүхэд гэр бүл цуцлалт зөрчилийн хэргээр холбон зуучилсан, 1 насанд хүрэгчийн гэмтлийн тасагт хэвтэн эмчлүүлж, 6 хүүхдийг хүүхдийн эмчид холбон зуучлан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн.

- Чансаа тогтоох XI парламентийн мэтгэлцээний тэмцээн зохион байгуулав. Тэмцээнийг Хөвсгөл аймгийн “Оюутны нэгдсэн холбоо”, Арвис мэтгэлцээний урлагийн клубтэй хамтран зохион байгууллаа. 2020 оны 01 дүгээр сарын 23-24 нд Аймгийн Хүүхдийн ордны 209 тоот “Залуучуудын хөгжлийн төв”-д тэмцээнд оролцогч хүүхдүүдэд сургалт орж 01 дүгээр сарын 25-27 нд 3 өдрийн турш тэмцээнийг зохион

байгууллаа. Тус тэмцээнд 11 ерөнхий боловсролын сургуулийн 104 багийн 208 хүүхэд, залуучууд, 9 багийн 18 багш насанд хүрэгч оролцлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр

- Эрүүл мэндийн байгууллагуудаас 2019 оны статистик тайлан, мэдээ авах тухай Эрүүл мэндийн газрын даргын А/120 дугаар тушаалаар Сум дундын эмнэлэг-5, сум, өрхийн эрүүл мэндийн төв-23, бага эмчийн ортой салбар-2, хувийн ортой эмнэлэг-11, хувийн үүдэн эмнэлэг-27, эм ханган нийлүүлэх байгууллага-6, хувийн эмийн сан-35, эргэлтийн эмийн сан, аймгийн нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, ЭМГ-н нийт 113 эрүүл мэндийн байгууллагуудаас 26 нэр төрлийн статистик тайлан мэдээг авч нэгтгэн Эрүүл мэндийн хагжлийн төвийн статистик мэдээллийн албанд хүлээлгэж өгч ажиллаа.

- Эрүүл мэндийн сайдын 422 дугаар тушаал, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 31 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын 2019 онд гүйцэтгэсэн ажлыг үнэлж байр эзлүүлэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс болон Эрүүл мэндийн яаманд тус тус хүргүүлэн ажиллаа.

- ЭМС-ын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан сэтгэл ханамжийн судалгааны загвар хүснэгтийн дагуу нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 29 байгууллагад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгч иргэдээс авсан судалгааг заалт тус бүрээр үнэлж нэгтгэн дүгнэлээ. Судалгаанд нийт 7283 хүн хамрагдаж, ерөнхий сэтгэл ханамж 84.5%-тай байна.

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан Шинэ Үндсэн хууль батлагдсаны түүхт 28 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 дугаар тушаал гарч Эрүүл мэндийн салбарын албан хаагчдад Монгол улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүхэн хөгжил, нэмэлт өөрчлөлтүүдийн талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын нийт 75 ажилчин албан хаагчдад хамрагдлаа.

- 2020 оны эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн захиалгыг 23 сумын эрүүл мэндийн байгууллага, аймгийн Нэгдсэн эмнэлгээс авч нэгтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн эм, эмнэлгийн хэрэгслэл худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч нарт бага насны хүүхдэд анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх, эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх, Эмнэлзүйн хүүхдийн өвчний цогц менежментийн шинэчилсэн хувилбарын танилцуулга зэрэг шинэ мэдээ мэдээлэл өгөх арга зүйн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Мөрөн сумын 13, хөдөөгийн 5 сумын СӨББ-ын эмч нар хамрагдсан байна.

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг өргөжүүлэх төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг ДЭМБ-д хүргүүллээ. Тус төсөл нь Улаан-Уул, Цагааннуур, Ренчинхлүмбэ сумдад 100% хэрэгжиж, төслийн өмнөх болон төслийн дараах мэдлэг дадлын судалгааг нийт 985 иргэнээс, төслийн дараах сэтгэл ханамжийн судалгааг 1005 иргэнээс авч нэгтгэн ажилласан.

- Тэмбүүг устгая үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн Мөрөн, Хөвсгөл телевиз, Хөвсгөлийн өнгө сайт, Хөвсгөлийн долгион радио, Эрх чөлөө сонинтой хамтран ажиллах гэрээг байгуулан төлөвлөгөөний дагуу 1 сард явуулах

мэдээллүүдийг 2 телевизээр тус бүр 2 удаа хөвсгөлийн өнгө пейж хуудсаар дамжуулан 10 удаагийн мэдээллийг Өрх, сум, ЭМГ-ын холбогдох хүмүүс хамтран хийлээ.

- Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын А/19 дүгээр захирамжийг гаргуулан ажиллалаа. Тус захирамжаар 2 эрүүл мэндийн байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл шинээр олгож, 3 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөлийг сунгаж, 4 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

- Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эх, хүүхдийн багийн дэмжлэгт хяналт Төмөрбулаг, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв болон Шинэ-Идэр, Улаан-Уул сумын Сум дундын эмнэлэгт тус тус дэмжлэгт хяналт хийлээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн онцгой байдлын комиссын 2020 оны 1 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А/12 дугаар захирамжаар 23 сум 1 тосгонд 148 тн өвс, 75 тн хүчит тэжээлийг малчдад олгохоор шийдвэрлэсэн. Тус захирамжийн дагуу өвс тэжээлийг хуваарийн дагуу өвөлжилт хүндэрсэн сумдад ачуулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 10 суманд 29 тн тэжээл, 38.3 тн өвсийг малчдад хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 15 суманд 12101 толгой мал хорогдсон. Үүнд: бод-1149, бог-10952 толгой мал хорогдсон. Эдгээр хорогдсон малаас өвчнөөр 190 толгой мал буюу бог-126, бод-64 хорогдсон байна.

Манай аймгаас гадны 4 аймагт 4 сумын 55 өрхийн 126 хүн үүнээс: Өндөр настан-54, хөгжлийн бэрхшээлтэй иргэн-5, хүүхэд-22, 27174 толгой мал отроор явсан. Өөрийн аймгийн 12 сумын нутагт 227 өрхийн 743 хүн үүнээс: Өндөр настан-36, хөгжлийн бэрхшээлтэй иргэн-35, жирэмсэн эх-7, хүүхэд-199, 111142 толгой мал отроор өвөлжиж байна. Мал аж ахуйн өвөлжилтийн цаг үеийн мэдээллийг 23 сум 1 тосгоноос малын зүй бусын хорогдлын мэдээ, отрын судалгааг нэгтгэж ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

Рашаант, Төмөрбулаг сумын мал эмнэлгийн тасгаас санаачлан Дэлхийн зөн ОУБ-ийн санхүүжилтээр “Манлай малчдын зөвлөгөөн”-ийг 2020 оны 1 дүгээр сарын 15-17-ны өдөр зохион байгууллаа. Уг зөвлөгөөний үеэр “Төмөрбулагчууд-Төмөрбулагчууддаа”, “Рашаантчууд Рашаантчууддаа” аяныг өрнүүлж 340 малчдаас 796 мал хандиваар цугларч амьжиргааны түвшин доогуур 6 өрхийг малжуулах шийдвэрийг зөвлөгөөнөөс гаргалаа.

Их-Уул сумын ЗДТГ, ИТХ, мал эмнэлгийн тасгаас “Иргэн танд” гарын авлага гарган Мал эмнэлгийн чиглэлээр гарсан хууль эрх зүйн бичиг баримт болон цахим системийн бүртгэлийн талаар мэдээлэлийг 800 малчин, иргэнд тараасан.

Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

БОАЖГ-аас орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу Дулааны станцын янданд утаа шүүгч төхөөрөмж байршуулахад шаардагдах зардлыг Дулааны станцаар гаргуулах шийдвэрт хүрч, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүсэлтээ албан бичгээр хүргүүлэв.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хүнсний ногоо тариалдаг “Талын шанд”, Ханх сумын “Саян радиан” жуулчны бааз, “Мөрөн вилла” орон сууцны барилга барих төсөлд хийлээ.

БОАЖЯ-нд уул уурхайн улмаас эвдэрсэн газрын тооллого, судалгааг гаргаж явуулав.

Хөвсгөл аймгийн өвлийн аялал жуулчлалын нөөцүүдэд түшиглэсэн дотоодын аялагч нарт зориулсан байгалийн болон сүсэг бишрэлийн маршрут гаргах талаар Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдтай хамтарсан судалгаа хийж, зөвлөмж чиглэл өгч ажиллав.

Нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөний бүтэц, агуулга, нөхөрлөлийн үйл ажиллагаа болон нөхөрлөлийн ойн менежментийн үйл ажиллагаанд хяналт-мониторинг, үнэлгээ хийх журмын төсөл зэрэг баримт бичгийн шинэчилсэн төслийг хэлэлцүүлэх уулзалт семинарт оролцож нөхөрлөлийг дэмжин ажиллаж буй талаар 25 иргэнд мэдээлэл хийлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2019 онд ашиглалтанд орсон 57, дуусаагүй 25 барилга байгууламжийн мэдээлэл судалгааг маягтын дагуу гаргаж санхүүжилтийн судалгааг аудитын газарт хүргүүлэв.

Ханх сумын Хичээлийн 1-р байрны барилгын их засварын ажлыг хүлээж авах, Ханх сумын төвд шинээр баригдсан Далайн захиргааны эргийн хамгаалалтын барилгыг байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан.

Зургийн даалгавраар Жаргалант сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Жаргалант сумын Спорт заалны барилга, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 11-р цэцэрлэг засвар, Хөвсгөл аймгийн Мөрөн сум 15-р цэцэрлэг 50 ортой цэцэрлэг, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын 100 ортой цэцэрлэг, Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ахмадын өргөө, Түнэл сумын Хүндэтгэлийн өргөө, Рэнчинлхүмбэ сумын Цаг уурын барилга Соёлын төвийн барилга Архитектур төлөвлөлтийн даалгаварт дээрх цэгүүд хамрагдлаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Цагаан-Үүр сумын Үүрийн голын Ган төмөр бетонон гүүрийн байгууламж дээр улсын комисс ажиллан 2020 оны 6 дугаар сарын 15 хүртэл хугацаанд дутуу ажлыг хийж гүйцэтгэх үүрэг даалгавар өглөө.

Мөрөн суманд шинээр 5 автобус нийтийн тээврийн үйлчилгээнд нийлүүлж байгаатай холбогдуулан Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Мөрөн сумын нутаг дэвсгэрт нийтийн зорчигч үйлчилгээг эрхлэх журмын төсөл боловсруулан ажиллаж байна.

2020 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ажлын болон зургийн даалгавар боловсруулан ажиллаж байна.

Долоо. Цаг үеийн бусад мэдээлэл:

Тариалан сум хөдөөгийн багуудын “Мэдээллийн цаг ажил”-ыг 2020 оны 1 сарын 22-оос 1 сарын 28 –ны өдрүүдэд хийж, 5 багийн 203 малчдад дараах мэдээлэл сургалт хийв.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэл, 2020 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын 2020 оны нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлт, (Малын хулгай)

Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлт, 2020 оны 1 сараас мөрдөгдөх шинэчлэн найруулагдсан хууль тогтоомжийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчдад хууль сурталчлах 14 хоногийн аяны хүрээнд

сумын Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Гал унтраах, аврах 46 дугаар ангийн нийт 80 гаруй албан хаагчдад сургалт мэдээлэл хийв.

Ханх суманд "ЦАС ЗҮСЭГЧ" богино хэмжээний баримтат кино зураг авалт зохион байгуулав. Энэхүү кинонд Улаанбаатар хотоос 1200 км, Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотоос 300 км алслагдсан Ханх сумын Эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эх баригч эмч Байгаль цаг уурын хүнд нөхцөлд тооцоолоогүй эрсдэл тулгарсан үед өргөсөн тангарагаа биелүүлж саад бэрхшээл эрсдэл бүхий хүнд замыг хэрхэн туулж алслагдсан тайгад амьдарч байгаа малчин өрхөд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байгааг харуулсан юм. Уг кино наадам 2020 оны 5-р сард Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 73 дахь чуулга уулзалт болох Женев хотод дэлгэн толилуулагдах болно.

Мөрөн сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан хүн ам өрхийн орон сууцны тооллогын ажлын хэсэг 2020 оны 1 дүгээр сарын 9-15-ны хооронд тооллогыг амжилттай зохион байгууллаа.

Мөрөн сумын 14 багийн Засаг даргын 2019 оны үйл ажиллагааны тайланд үнэлэлт, дүгнэлт өгөх багуудын иргэд нийтийн хуралдааныг 2020 оны 1 дүгээр сарын 20-25-ны хооронд зохион байгуулав.

Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай Эрүүл мэндийн газрын даргын А/06 дугаар тушаал батлагдан гарсан ба уг тушаалаар шуурхай хариу арга хэмжээ, эмнэлзүй, эрсдлийн мэдээлэл харилцааны багийг тус тус томилон ажиллаж байна. Аймгийн онцгой комиссын хурлаар нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл бусад зүйлс, авто тээвэр, нисэх буудал, хилийн гаальд хэрэглэгдэх халдваргүйтгэл, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн тооцоо судалгааг гарган хэлэлцүүлж 5674900 төгрөгийг шийдүүлэн зарим хувцас хэрэгслийн захиалгыг өгсөн.

Ханх суман дахь хилийн мэргэжлийн хяналт, гаалийн хороо, хилийн боомттой хамтран шинээр дэгдэж буй Корона вирустэй холбоотой мэдээ мэдээлэл солилцож сургалтыг Хилийн боомт дээр явууллаа

Вирустай холбоотой аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллүүдийг тухай бүр цахимаар хүргүүлэн ажиллаж байна.